



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Төлөвлөгөөг хянасан:
Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга
(албан тушаал)

Ж.Тамир/
(огноо)

Тэмдэг

Төлөвлөгөө баталсан:
Засгийн газрын байгууллагын нийтлэг үйлчилгээний газрын захирал
(албан тушаал)

Ю.Лувсанренчин/
(огноо)
2022.01.13

Тэмдэг

“ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР” ТӨААТУГ-ЫН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэгж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа II-IV улирал/	Хариуцах нэгж
Үйлчлүүлэгч байгууллага бүртэй байгуулсан гэрээний үүргийг бүрэн биелүүлж, харилцан үр ашигтайгаар урт хугацаанд хамтран ажиллах							
1.	“Ажлын байрны хэвийн, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх” хүрээнд:	2,6 тэрбум төгрөг	Төрийн байгууллага, тэдгээрийн албан хаагчид ажил үүргээ хэвийн таатай орчинд гүйцэтгэх нөхцөлийг тогтмол бүрдүүлэн ажиллах.	Үйлчлүүлэгчдэд ISO 9001:2015 шаардлага хангасан үйлчилгээг тогтмол үзүүлэн ажилладаг.	ISO 9001:2015 стандартад нийцэх үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлэхдээ тэдгээрийн сэтгэлд нийцсэн байхаар ажилласан байх.	Жилийн турш	Бүх хэлтэс
1.1	Цэвэрлэгээ үйлчилгээний ажил гүйцэтгэх	334,8 сая төгрөг	ISO 9001:2015 стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх	Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 олон улсын шаардлагын шаардлага хангасан тул ISO 9001:2015 гэрчилгээ, Тухайн стандартад нийцүүлэн	Стандарт, хэмжил зүйн газраас жил бүр хийдэг төлөвлөгөөт шалгалтанд /ISO 9001:2015/ хангалттай үнэлгээ авч, үргэлжлүүлэн эзэмшсэн байна; Тухайн стандартад нийцүүлэн	Жилийн турш	Бүх хэлтэс

1.2	Эрүүл ахуйн хяналт, ариутгалын үйлчилгээ хийж ажиллах.	19,5 сая төгрөг	Монгол Улсад бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан бодисоор, технологийн горимийг хангасан ариутгал, халдваргүйтгэл хийх	Тэмдэглэгээг хэрэглэх эрхийг 3 жилээр буюу 2021-2024 онд дахин үргэлжлүүлэн эзэмших эрх авсан.	Бүх өрөө, тасалгаанд халдваргүйтгэл, ариутгал, шавьжийн устгал /65015.2 м.кв/ хийж эрүүл, цэвэр, аюулгүй орчин бүрдүүлсэн байна.	Жилийн турш	Үйлчилгээний хэлтэс
1.3	Хог хаягдлыг ангилан ялгалтыг эх үүсвэр дээр нь хийж, хэвших	56,7 сая төгрөг	Байруудад шинэ дэвшилтэт арга барилыг нэвтрүүлэн хог хаягдал үүссэн цэгээс түүнийг ангилан ялгах, цуглуулах, түр байршуулан ажилласан байх.	Харьяа 14 байруудын хог хаягдлыг саалан цуглуулж, түр байршуулан, гэрээт аж ахуй нэгжээр тээвэрлүүлдэг.	Харьяа байруудын 2-оос доошгүй байранд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж ялган, цуглуулах дадлыг хэвшүүлсэн байна; Дахин ашиглах болон дахин боловсруулах хаягдлыг холбогдох аж ахуй нэгжид нийлүүлэн ажиллах.	III, IV улиралд	Бүх хэлтэс
1.4	Цай үйлчилгээгээр үйлчлэх	19,7 сая төгрөг	Эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүнээр эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллах	Стандартын дагуу зочид, үйлчлүүлэгчдэд цай, кофе зэргээр тогтмол үйлчилдэг	Цайны үйлчилгээний NUG-S-006 стандартад нийцсэн үйлчилгээг хэрэглэгчдэд тогтмол хугацаанд хүргэн ажиллах.	Жилийн турш	Үйлчилгээний хэлтэс
1.5	Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэг, ногоон байгууламжийг арчлан хамгаалж, тарьж ургуулах	28,0 сая төгрөг	Ургуулж буй 3145 ширхэг цэцэг, 4756 метр квадрат талбайг зүлэгжүүлэх болон 138 цэцгийн мандал зэргийг байгуулсан, арчлан хамгаалсан эсэх;	Харьяа байруудад 3145 ширхэг цэцэг арчилж, 4756 метр квадрат талбайд зүлэгжүүлж, 138 цэцгийн мандалд цэцэг тарьж ургуулдаг.	Гадна, дотор талын ногоон байгууламжийг арчлан ажилласнаар ашигтай, хүний эрүүл мэндэд тустай цэцгийн нэр төрөл, мод зэргийн тоо хэмжээ нэмэгдэж, орчны тохижилт сайжирсан байна.	II, III улирал	Үйлчилгээний хэлтэс
1.6	Коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байх.	25,5 сая төгрөг	Коронавирус /Ковид-19/ цар тахлын үед үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлага, дүрэм журмыг мөрдөн ажиллах;	Коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлчилгээний байгууллагуудын мөрдөн ажиллах дэглэм, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.	Коронавирус /Ковид-19/ цар тахлын үед үйлчилгээний байгууллагуудад тавигдах шаардлага, дүрэм журмыг мөрдөн, тогтмол шинэчлэн ажиллана.	Жилийн турш	Бүх хэлтэс
1.7	Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэн ажиллах	20,0 сая төгрөг	Цэнэггүй болсон галын хорыг тухай бүрт нь 100 хувь цэнэглэсэн эсэх;	Галын хорын даралтыг тогтмол шалгаж, даралтгүй болох үед нь тухай бүр	Даралтгүй болсон галын хорыг тухай бүрт нь цэнэглэж ажиллана.	Жилийн турш	Барилга, инженер техникийн

1.8	Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг тогтмол хангаж ажиллана.	993,0 сая төгрөг	"Гал түймэр, газар хөдлөлт, гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах тухай" сэдвээр сургалтыг зохион байгуулсан эсэх;	дахин ажилладаг. Харьяа байруудын ажиглалтад "Газар хөдлөлт, гамшиг ослын үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах бэ?" сэдвээр бодитоор үзүүлэх сургалтыг Төрийн ордны онцгой байдлын албатай хамтран зохион байгуулдаг	Харьяа байруудын цахилгааны далд монтажийн 70.0 хувь нь ажиллалтын шаардлага хангахгүйгээс галын аюултай байдлын түвшинд байна. Мөн цахилгааны утас болон өрөө тасалгааны гэрэлтүүлэх хэрэгсэл хуучирч, элэгдэж муудсан. Иймд тогтмол хугацаанд засвар үйлчилгээний ажил хийдэг.	Харьяа байруудын цахилгаан хангамжийн тоноглолын ашиглалтын хэвийн ажиллагааг ханган ажилласнаар үйлчлүүлэгчид жилийн турш цахилгаан хангамжаар найдвартай ажилласан байх.	Жилийн турш	Барилга, инженер техникийн хэлтэс
1.9	Ус, дулаан хангамжийн найдвартай ажиллагааг тогтмол ханган ажиллана.	615,6 сая төгрөг	Ус, дулааны шугам сүлжээний тоноглолд засвар үйлчилгээний ажил хийж, өвөлжилтийн бүрэн бэлтгэлийг хангасан байх.	Ус, дулааны шугам хоолой, насос, бойлер зэрэг хэрэгсэлүүд моралын элэгдэлд орсноос шалтгаалан шинэчлэх шаардлагыг эрх бүхий байгууллагаас тавьдаг. Өрөө тасалгааны өнгө үзэмжийг жил бүр засаж сайжруулан үйлчилгээг хийдэг	Ус, дулааны шугам хоолой, насос, бойлер зэрэг хэрэгсэлүүд моралын элэгдэлд орсноос шалтгаалан шинэчлэх шаардлагыг эрх бүхий байгууллагаас тавьдаг. Өрөө тасалгааны өнгө үзэмжийг жил бүр засаж сайжруулан үйлчилгээг хийдэг	Харьяа байруудын уэльд элэгдэж муудсан халуун усны ялтсан бойлер, халуун усны автомат, халаалтын нөөц насос зэргийг суурилуулан, өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн ханган ажилласан байх.	Жилийн турш	Барилга, инженер техникийн хэлтэс
1.10	Барилга, засвар мужааны үйлчилгээг хийж гүйцэтгэх	466,1 сая төгрөг	Байгууллагаас тавьсан хүсэлт болон ерөнхий хэрэгцээ шаардлагад үндэслэн барилгын засварын ажил хийх	Байгууллагаас тавьсан хүсэлт болон ерөнхий хэрэгцээ шаардлагад үндэслэн барилгын засварын ажил хийх	Байгууллагаас тавьсан хүсэлт болон ерөнхий хэрэгцээ шаардлагад үндэслэн барилгын засварын ажил хийх	Элэгдэж муудсан дээвэр, ариун цэврийн болон албан өрөө, тасалгаа зэрэг нийтдээ 20-аас доошгүй өрөө, талбайд засвар тохижилтын ажил хийнэ.	Жилийн турш	Барилга, инженер техникийн хэлтэс
1.11	Лифт болон агаар сэлгэх хэрэгсэлийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.	40,0 сая төгрөг	"Лифт, агаар сэлгэлтийн хэрэгсэлийг аюулгүй ажиллах дүрэм"-ийг баримтлан осол авааргүй ажиллах.	Лифтэнд сар бүр мэргэжлийн байгууллагаар үзлэг шалгалт хийлгэж гарсан зөрчил дутагдлыг засаж ажилладаг.	Лифтэнд сар бүр мэргэжлийн байгууллагаар үзлэг шалгалт хийлгэж гарсан зөрчил дутагдлыг засаж ажилладаг.	Мэргэжлийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийг мөрдөн ажилласнаар аюул, осол гаргахаас урьдчилан сэргийлж ажилласан байх.	Жилийн турш	Барилга, инженер техникийн хэлтэс

2.	"Хүний нөөцийн удирдлага, байгуулалтыг зорилтын хүрээнд:	252,4 сая төгрөг	Ажилтан, албан хаагчдыг ажлын байран дээр суралцах, хөгжих боломж, хамгаалах нөхцөлөөр хангах	Хүний нөөцийн бүрдэлт, сургалт, хөгжүүлэлтийг тогтмол хийж ажилладаг.	Чадварлаг, суурьшилтай ажиллах боловсон хүчинг хөгжүүлж, хүний нөөцийг манлайллыг хөгжүүлж ажиллана.	Улирал бүр	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах	88,0 сая төгрөг	Хөдөлмөрийн аюул осолгүй ажиллах.	Ажлын байран дээр хөдөлмөрийн аюулгүй осол байдлын бүртгэгдээгүй.	Хүний эрүүл мэндэд хамгийн бага сөрөг нөлөөтэй бараа материал, багаж хэрэгсэл ашиглан, сургалт хөгжүүлэлтийг тогтмол хийж ажиллах.	Жилийн турш	ЗХНХ, БИТХ, Үйлчилгээний хэлтэс
2.2	Хүний нөөцийн бүрдэлт, сургалт хөгжүүлэлт, буцалтгүй тусламж, шагналыг урамшууллыг хийж ажиллах	158,4 сая төгрөг	Хүний нөөцийн бүрдэлтийг тогтмол хийж, хөгжүүлэх, тусалж дэмжих	Хүний нөөцийн бүрдэлтийг тогтмол хийж, сургаж, тусламж дэмжлэг үзүүлдэг.	Хүний нөөцийн бүрдэлтийг ил тод, нээлттэй хийж, ажлын байран дээр сургаж, тэтгэмж болон буцалтгүй тусламж дэмжлэг үзүүлсэн байх.	Улирал бүр	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
2.3	Дотоод аудит, хяналт шинжилгээ, хууль, эрх зүй, чанар стандартыг хангах үйлчилгээ	6,0 сая төгрөг	Байгууллагын үйл ажиллагааг хууль, хүрээнд стандартын явагдаж, шинжилгээ хийгдэж байх.	Жил бүр Стандарт, хэмжил зүйн газрын шалгалтанд хамрагдаж, гадна болон доторх аудитын шалгалт хийгддэг.	Байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын дагуу явуулж, цаг тухай бүрт нь хууль эрх зүйн нэмэлт өөрчлөлтийг оруулан ажилласан байх.	Жилийн турш	Захиргаа, хүний нөөц болон Санхүү, бүртгэлийн хэлтэс
3	"Гадаад хамтын хөгжүүлэх" зорилтын хүрээнд:	8,5 сая төгрөг	Туршлага судалж, шинэ арга барил, технологийг нэвтрүүлэх	2021 онд ХБНГУ, Бүгд Найрамдах Австри Улс, ОХУ зэрэг улсуудын барилга байгууламжийн засвар үйлчилгээний үйл ажиллагааг интернэтээс судалж, туршлага судлан ажилласан.	Нийтлэг үйлчилгээнд ашиглаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, давуу тал, шинэлэг арга туршлагаас нэвтрүүлэн ажиллах. Гадаад нэгээс доошгүй улсын нийтлэг үйлчилгээний ажлыг нарийвчлан судлан ажиллана.	Жилийн турш	Бүх хэлтэс
3.1	Төрийн байгууллагад үзүүлдэг үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор гадаад улсын болон дотоодын ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, туршлага судлах, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах;	8,5 сая төгрөг	Дотоодын нэгээс доошгүй байгууллагатай хамтран ажиллаж, харилцан туршлага солилцон ажилласан байх; Гадаадын ижил төстэй байгууллагын үйл ажиллагааг судалж ажиллах;	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар, орон нутгийн ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас туршлага судалж, харилцан үр ашигтай хамтран ажилладаг. Гадаад улсын ижил төстэй байгууллагын үйл ажиллагааг судалдаг.	Дотоодын нэгээс доошгүй шинээр ажилласан байгууллагатай харилцаа холбоо тогтоож, харилцан үр ашигтай хамтран ажилласан байх. Гадаад улсын ижил төстэй нэгээс доошгүй байгууллагын үйл ажиллагааг нарийвчлан судлан, мэдээллийн бааз үүсгэх.	Жилийн турш	Бүх хэлтэс
4	"Санхүү, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг удирдан ажиллах" зорилтын хүрээнд:	6,0 тэрбум төгрөг	Орлогоороо санхүүжиж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байх.	Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажилладаг.	Хөрөнгө санхүүгийн хувьд үйл ажиллагаа хэвийн санхүүжүүлж ажилласан байх.	Жилийн турш	Санхүү, бүртгэлийн хэлтэс

4.1	Төсөв төлөвлөгөөт хэмжээнд төвлөрүүлж, үр ашигтай зарцуулж ажиллана.	6.0 тэрбум төгрөг	Өмнөх оны мөн үед олох төлөвлөгөөт орлогоос тухайн оны мөн үед олох орлогыг бууруулахгүй ажиллах;	2021 онд нийт 6.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	Орлогыг нэмэгдүүлж, зарцуулалтыг үр ашигтай хийсэн байх.	Жилийн турш	Санхүү, бүртгэлийн хэлтэс
4.2	Өмч хөрөнгийн менежментийг сайжруулан ажиллах	---	Өмчийн бүртгэл тооллого, ашиглалтыг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байх	Эрх бүхий байгууллагаас 2020 онд өмчийн менежментийг үлгэр жишээ явуулсан гэж үнэлсэн.	Төрийн өмч хөрөнгийн бүртгэл, тооллого хийж, ашиглалтыг сайжруулан, эд хөрөнгийн ямар нэг зөрчилгүй ажилласан байх.	Улирал бүр	Санхүү, бүртгэлийн хэлтэс
4.3	Харьяа байруудад байрлах төрийн байгууллагуудын байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний чиглэлээр улсын төсөвт тусгуулан батлуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтын ажлын тооцоо төсвийн боловсруулж, тухайн байгууллагуудад хүргүүлэн ажиллах;	---	Харилцагч байгууллагуудтай хамтран ажиллах болон хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн талаар мэдээлэл хүргүүлж хамтран ажилласан эсэх	Харьяа байруудад байрлаж үйл ажиллагаа явуулж буй 81 /Ажил, нийтлэг үйлчилгээ гүйцэтгэх-36, түрээс-12, гаж-12, бусад-21/ байгууллагатай гэрээ байгуулсан.	Харьяа байруудад байрлан ажилладаг байгууллагуудад төрийн байр ашиглалт, нийтлэг үйлчилгээний ажлын чиглэлээр ирэх жилийн төсөвт ямар хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын ажил тусгуулах шаардлагатай тухай саналыг хүргүүлж ирэх онд хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцсэн байх.	Жилийн турш	Санхүү, бүртгэлийн хэлтэс Захиргаа, хүний нөөцийн хэлтэс

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС